

Өрсөлдөөний ардчиллаас зөвшилцлийн ардчилалд

Аюурзанын Цанжид, доктор (Sc.D)

Шинжлэх Ухааны Академи, Философийн хүрээлэн

Бодлого судлалын салбар, Улаанбаатар, Монгол Улс

tsanjid@mas.ac.mn, <https://orcid.org/0009-0003-8562-0355>

Ардчиллын тухай сэдэв нь өнөөдөр улс төрийн философийн хамгийн их анхаарал татсан асуудал болж байна. Сүүлийн гучаад жилийн дотор ардчиллын өрнөл, давамгайллын тухай өөдрөг үнэлгээ нийгмийн ухааны эрдэмтэн судлаачдын санаа нэгтэй дүгнэлт байснаа түүний хямралын тухай яриагаар солигдов. Ардчиллын үлгэр загвар болдог гэж үздэг орнуудын улс төрийн амьдралд сүүлийн үед өрнөж байгаа үйл явдал ч үүний гэрч мэт харагдаж байна. Урьд өмнө байсан болон мэдээлэл, холбооны технологийн хөгжил, нийгмийн сүлжээ гэх мэттэй холбоотой сонгуулийн бохир технологи, хөдлөнгийн оролцоо, сонгуульд нэр дэвшигчийг мөрдөж мөшгөх, янз бүрийн аргаар нэр дэвших эрхийг нь хасах, хязгаарлах зэрэг урьд хожид байгаагүй сөрөг үзэгдлүүд гарах болов. Сонгогчид “төвийн” гэж нэрлэгддэг намуудад итгэх нь багасаж, хэт барууны намуудыг дэмжих хандлагатай боллоо. Уламжлал ёсоор үзэл бодлоороо нэгдсэн хүмүүсийн холбоо гэж үзэгддэг улс төрийн намуудад олигархжих шинж ажиглагдах болжээ. Нөгөө талаас сонгогчид өөрчлөгдөж байна. Хөгжиж буй орнууд ардчиллын өөрийн загварыг олохгүй, өрнөдийн либерал ардчиллын загварыг хуулбарлаж байгаа нь ихэвчлэн хэлбэрдэх маягтай байгаа ба агуулгыг нь хувийн эрх ашгийг эрхэмлэсэн улс төрчдийн улайрсан өрсөлдөөн бүрэлдүүлж байна. Үүний зэрэгцээ

либерал бус ардчилал гэдэг ойлголт буй болсон ба ийм ардчилал бүхий зарим оронд төрийн үйл ажиллагааны үр нөлөө эдийн засаг, нийгэм талаас нь харвал өндөр байна. Энэ бүхнийг үндэслэн нэлээд олон судлаач ардчиллын хямралын тухай ярьдаг, бичдэг болсон байна.

Гэвч ямар ардчиллын тухай, ямар хямралын тухай ярьж байна вэ гэдгийг тунгаах шаардлагатай юм. Ардчиллын үзэл санааны хямралын тухай ярьж байна уу, ардчиллын практик, өдийг хүртэл баримталж ирсэн загварын хямралын тухай юу?

Ардчиллын тухай гэдэг нь либерал ардчиллын тухай гэдэг нь ойлгомжтой. Түүний үндсэн үзэл санаа нь хүн бүрийн эрх эрх чөлөө, үнэ хүндийн тухай асуудал байдаг. Тийм болохоор өнгөц харахад ардчиллын энэхүү үзэл санаа хямрах тухай асуудал байж боломгүй мэт санагдаж байгаа юм. Өнөөгийн ертөнцөд хэн хүний эрх, эрх чөлөөний эсрэг үг хэлж зүрхлэх вэ? Гэвч тийм биш бололтой. Германы профессор Г. Розмозер бодит социализм нуран унасны дараахан бичсэн сонирхолтой номдоо орчин үеийн өрнөдийн нийгэмд ноёрхож буй улс төрийн философи оюун санааны өндөр зорилго байхгүй учраас тулгарч байгаа асуудлууд үүний дотор улс төрийн хүрээний тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чадваргүй байна хэмээн шүүмжилжээ. Түүний үзэж байгаагаар өрнөдийн ертөнц социализмын сөрөг

хувилбар гэдгээрээ оршин тогтнож ирсэн бөгөөд “социализмын ачаар” оршин тогтнож ирсэн бол бодит социализм нуран унахын хамт өрнөдийн либерализмын сөрөг талууд тодрон гарч ирсэн аж. Өрнөдийн нийгэм зөвхөн эдийн засгийн категориор сэтгэж, эдийн засгийн зорилгыг хэрэгжүүлэхдээ социализмаас илүү хэмээн оршин тогтнолоо зөвтгөж ирсэн аж. Гэтэл социализм үгүй болсноор өрнөдийн нийгэм айхтар асуудалтай тулгарсан нь тэр чухамдаа өөрийн философигүй байсан нь илэрсэн гэнэ. Тиймээс орчин үеийн либерал үзэл санааг шинэчлэх, ингэхдээ эх булаг руугаа эргэх, консерватизмтай хавсрах хэрэгтэй гэж үзжээ. Либерал ардчиллын үзэл санаа, философи үндэслэлийг нухацтай тунгаан үзэх нь чухал гэдэг нь түүний хямралын тухай онолын яриа хэлэлцүүлгээс ил байна.

Либерал ардчиллыг нийгмийн амьдралд хэрэгжүүлж буй практикийн хувьд хямралын тухай биш гэхэд сөрөг талууд нь урьд өмнөх үеэс илүү тод илэрч байгаа тухай ярьж болох юм. Энэ нь магадгүй аливаа зүйл удахад буй болдог зүй тогтлын шинжтэй үзэгдэл ч байж болох юм. Монголын их бичгийн хүний нэг Ч. Дэмчигдорж зуу гаруй жилийн өмнө энэ талаар бичиж байсныг эргэн санахад илүүдэхгүй юм. Тэр бээр, “аливаа бодос туйлд хүрвээс эрхгүй мохно. Мохвоос эрхгүй хувьсана. Хувьсваас эрхгүй нэвтэрнэ. Аливаа их бага үйлсийг ялгахгүй жил удахад яван явсаар гэм сэв орж хувьссаар уг дүрмээс өшүүд өөр болоход хүрнэ. Үүний дээр бас цаг улирлын хувьсал адилгүй тул энэ хоёр зүйл хавсарваас эрхгүй буурч доройтно” гэжээ (Ч. Дэмчигдорж, 1995,). Гэвч энэ нь тухайн юм заавал ч үгүй мөхөж, сөнөнө гэсэн үг биш. “Ер нь аливаа юм удваас хуучирч эвдрэхэд хүрэх нь байдалд өөр болох нь буюу. Үүнийг цаг цагт сэлбэн засваас шинэ болж үл эвдрэх нь мөнхүү өөрөө тогтсон

ёс болой”. XX зууны эхэн үеийн утга зохиолын монгол хэлээр бичсэн эл санааг залуус дүү нар бүрэн ухахгүй байх магадлалтай учир түүнийг бяцхан тайлбарлая.

Аливаа зүйл удаан хугацаагаар оршин тогтновол сөрөг тал нь бага багаар өсөн том болсоор уг юмны мөн чанар, анхны зорилгод харшилж эхэлнэ.

Ийнхүү уг зүйл өөрөө муудаж хуучрахын зэрэгцээ цаг үе, орчин нөхцөл өөрчлөгдөнө.

Эл хоёр хүчин зүйлийн нөлөөгөөр уг юм бүр ч доройтож муудна.

Гэвч ийм үйл явц эргэлт буцалтгүй биш. Цагийг нь олж гэм сэвийг нь засаж чадваас үл эвдрэх төдийгүй шинэ болно. Энэ бол аливаа үзэгдэл, юмсын “өөрөө тохирох ёс” буюу зүй тогтол мөн.

Төстэй үзэл санааг эртний Грекийн сэтгэгчид, тухайлбал, Платон улс төрийн байгууллаар жишээ татан илэрхийлж байсан билээ. “Засаглалын бүх хэлбэрүүд өөрсдийн үндсэн зарчмыг хэтрүүлснээр мөхдөг. Аристократ засаглал нь эрх мэдлийг хэт нарийсгасан хүрээнд хязгаарласнаар өөрийгөө сүйрүүлдэг; олигархи нь шууд хөрөнгө хураахын төлөөх болчимгүй тэмүүлээрээ өөрийгөө устгадаг. Аль ч тохиолдолд төгсгөл нь хувьсгал байдаг... ардчилал хүртэл — ардчиллынхаа хэтрэлээр — өөрийгөө мөхөөдөг. Түүний үндсэн зарчим нь бүх хүнд албан тушаал хаших, төрийн бодлогыг тодорхойлох тэгш эрхийг олгох явдал юм. Энэ нь анх харахад таатай зохион байгуулалт мэт санагддаг; гэвч ард түмэн хамгийн шилдэг удирдагчдыг сонгож, хамгийн ухаалаг замыг тодорхойлох боловсролгүй учраас энэ нь гамшигт хүргэдэг.” (Will Durant, 1990,26-27) Платоны дилемм буюу ад асуулт гэж нэрлэдэг эл асуудлыг одоо болтол шийдвэрлэж чадаагүй байгаа билээ. Энэ талаар бид хойно дахин хөндөх болно. Ардчиллын хямралын тухай яриа зөвхөн одоо ч гарч байгаа хэрэг биш. 1960 -аад

оны залуу үеийнхний эсэргүүцлийн хөдөлгөөн болон бас бус шалтгаанаар 1973 онд баруун Европ, Хойт Америк болон Японы хувь хүмүүсийн санаачилгаар Тэр үеийн улс төрийн амьдралыг судлах зорилго бүхий “Гурван талт комисс” гэдгийг байгуулсан гэдэг. Гол судлаачид нь Мишел Крозье, Самуел П. Хантингтон, Жожи Ватануки нар байсан. Тэд Гурван талт комисст зориулсан илтгэлээ “Ардчиллын хямрал: ардчилсан нийгмүүдийн засагт захирагдах байдал” хэмээн нэрлэсэн нь хямралын тухай асуудал хуучин биш гэдгийг харуулж байгаа юм. “The governability of democracies” гэсэн нь нийгмийн өөрийн нь засагт захирагдах шинж чанарын талаар ярьж байгаа хэрэг юм. Тэд нийгэмд тодорхой асуудлууд үүсэн буй болсон нь ардчиллын өөрийн үйлчлэлийн нэг хэсэг мэт харагдаж байна гээд ардчилсан төр амжилттай ажиллаж байгаа нь түүний энэхүү үйл ажиллагаанд саад болж буй зарим дараах үзэгдлийг буй болгож байна гэжээ. Үүнд:

1. Тэгш эрх, индивидуализмын талаар ардчилсан үнэлэмжийг хөхиүлэн дэмжсэн нь төрийн эрх мэдлийн легитимт байдлыг бууруулж, хошуучлалд итгэх итгэлийг үгүй болгож байгаа,

2. Улс төрийн ардчилсан оролцоо түгээмэл болж, өргөжсөн нь төрийн “хэт ачааллыг буй болгосон,

3. Ардчилалд чухал ач холбогдолтой улс төрийн өрсөлдөөн эрчимжиж, сонирхлуудыг задалж сарниулан улмаар улс төрийн намууд ч жижгэрч, уналтад орж эхэлсэн.

Энэхүү дүгнэлтийг ажиглаваас ардчилал нь ардчилал хэт ихэдсэнээс нуран унадаг гэсэн Платоны дүгнэлт эрхгүй санаанд бууна. Г. Розмозер XX зууны төгсгөл үеийн байдлыг тодорхойлж, “Либерализмын хямрал”-ын тухай ярихдаа би дурдсан бүх асуудлын

дотроос хамгийн түрүүнд либерал соёлын хямралыг хэлж байна. Бид либерализмын бүрэн эрхэнд орж, түүний гажуудсан хэлбэр болох либетаризмд үг дуугүй бууж өгч байгаа нь хувь хүнчлэх, нийгмийг хагалан бутаргах, гедонизм ноёрхоход хүргэсэн. Үүний үр дүнд бид дотоод элэгдэл, тэр ч байтугай нийгэм задрах шинж тэмдгүүдтэй байнга тулгардаг. Бид үнэт зүйлсийн мөхлийн тухай, соёлын хямралын тухай ярьж байна. Ухамсрын тогтворгүй байдал нь улс төрд ч зайлшгүй нөлөөлдөг.” (Г. Розмозер, 1996, 21-22) Түүний энэ дүгнэлт нийгмийн гүнд болж байгаа газар хөдлөхөд болдог шиг гүний үзэгдэл, өөрчлөлтийг хөндөж байна.

Өөр нэг эрдэмтний үгийг бас эш татъя. Ямар ч тодорхой агуулгагүйгээр эрх чөлөөг тунхаглах нь хүсмээргүй байдалд хүргэж байгааг Америкийн хүмүүнлэгийн ухааны холбооны 2003 оны хүнээр шалгарсан Шервин Уайн интернэтийн “Өнөө цагийн гуманизм” хэмээх хуудаст бичсэн байна. Тэр бээр хэрэглээний эд таваар бялхсан, сонголтын хязгааргүй их боломжтой мэт харагдаж байгаа өнөөгийн нийгэмд эрх чөлөө нь эхэн үеийн гуманистуудын тааварлаж байгаагүй тийм үр дагаврыг буй болгож байгааг анхааруулсан байна. “Хүмүүс эрх чөлөөгөө залхуурах, хувиа бодох, өөрийгөө эвдэхэд ашиглах боллоо. Засгийн газар, хамт олон, гэр бүлийн алийн нь ч байсан нийгмийн зүгээс захирах аливаа хэлбэрийг ёс суртахууны бузар муу зүйл гэж үздэг хувьч үзлийн шашин цэцэглэн хөгжиж байна. Субъективизм, аливаа объектив үнэнд захирагдахаас татгалзах явдал газар авч, шинжлэх ухааны сахилга батыг хувийн зөн совингоор сольж байна. Социаль хөдөлгөөн бүхий нийгэмд үндэс язгуураасаа тасраад удаж байгаа хүмүүс сонголтынхоо бусад хүмүүст үзүүлэх үр дагаврыг үл хайхран хэрэглээний соёлын хүрээнд сонголт хийж, эд зүйлс нэмэн нэмэн авсаар тэнэж

явна. Олон хүмүүс гадуурхагдсан, ганцаардсан мэдрэмжтэй болсон энэ цаг үед эрх чөлөөг ёс төдий магтан дуулах нь хангалтгүй. Бид эрх чөлөө гэж юу гэсэн үг вэ гэдгийг дахин эргэцүүлэн бодож, түүнд тохиолдож буй туршлагаас үүдэлтэй хязгаарлалтуудыг эргэн харах ёстой. Эрх чөлөөний төлөөх суртал ухуулгыг үл хайхран өнгөрсөн хоёр зууны түүхээс харахад түүнийг төлөвшүүлэхэд түүнээс илүү үнэт зүйл бий гэдгийг харуулж магадгүй юм.”(Sherwin T. Wine)

Судлаачдын иймэрхүү маягийн дүгнэлтүүдийг би өмнөх нэгэн өгүүлэлдээ олон эшилсэн учраас энэ удаад үүгээр хязгааръя. (Ардчиллын хямрал ба Монголын ардчиллын ирээдүй)

Ийнхүү янз бүрийн цаг хугацаанд хийсэн удаа дараагийн судалгааг үзвэл ардчилал бол хөдлөнгө шинжтэй, үе үе хямралт үзэгдэл буй болдог нарийн үйл явц ажээ. Үе үеийнхний үнэлэмж, боловсролын төвшний өөрчлөлт, техник, технологийн хөгжил гэх мэт хүчин зүйлийн улмаас цаг үеийн онцлогт нийцэж өөрчлөгдөж байх учиртай аж. Хөгжингүй орнууд дэлхийн хоёрдугаар дайны дараахан үеийн ардчиллын загварыг баримталж, түүний хөгжиж буй орнууд хуулбарлах гэж оролдож байгаа нь хямралт үзэгдлийг буй болгосон байна. Дандаагийн хэлсэнчлэн “гэм сэв” нь томорч, удаан хугацаанд үйлчилснээр Розмозер, Уайн нарын ажигласан сөрөг зүйлс бий болжээ. Ийм сөрөг зүйлс ардчиллын олон жилийн уламжлалтай өрнөдийн орнуудад юуны буй болсон ба энэ замналыг дагаж байгаа бусад оронд ч шинж тэмдэг нь мэдрэгдэж байгааг би дээр дурдсан өгүүлэлдээ тэмдэглэсэн билээ. Орчин үед технологийн хөгжилтэй холбоотой өөрчлөлт, геополитикийн өөрчлөлт болон үнэлэмжийн өөрчлөлт гэсэн гурван том өөрчлөлт дэлхий дахиныг хамарч байна. Энэ нь ардчилалд ч нөлөөгөө үзүүлж

байгаа ба ардчиллын “үндэсний” гэмээр хэв маягийн эрэл хийх шаардлагыг буй болгож байгаа ч байж болох юм.

Ардчиллыг тухайн нөхцөл байдалд нийцүүлж, илүү үр нөлөөтэй болгохын тулд түүний мөн чанарыг сайтар ойлгох хэрэгтэй юм. Өрнө дорнын улс төрийн философид зарчмын ялгаа байдаг нь өрнөдөд төрийн эрхийг хэн барих вэ гэдэгт гол анхаарлаа хандуулж ирсэн. Тиймээс Аристоттель, Платоны үеэс л төрийг олон, цөөн, нэг хүн барих, философичид барих гэх мэтээр судалж шинжилж ирсэн байдаг. Харин дорно дахинд, ялангуяа Хятадын философичид төрийн эрхийг хэн барих вэ гэдэгт бус төрийг хэрхэн жолоодох вэ гэдэгт анхаарлаа хандуулж байжээ. Өрнийн давамгайлж буй либерал философийн гаргалгаа нь хүн эрх чөлөөтэй байж, өөрийн хичээл зүтгэл авьяас чадвараар хэрхэн амьдрахаа шийдвэрлэх ёстой гэж үзэх явдал юм. Харин дорно дахинд төрийн үйл ажиллагааны ёс суртахууны талыг онцолж, төр ёс суртахуунтай сайн ажиллаж, өрхийн тэргүүн мэт иргэдийнхээ аж амьдралд анхаарал тавих ёстой гэж үзэж иржээ. Өнөө үед Хятад, Вьетнам, Лаос, Камбож гэх мэтийн Азийн орнуудад ийм философийг баримталж байна уу гэлтэй. Японд ч гэсэн Либерал ардчилсан нам удаан хугацаагаар төрийн эрх барьж байгаа нь эл философийн нөлөө байж болох юм. Тийм учраас Ази маягийн ардчилал байж болохыг үгүйсгэхгүй ба үнэхээр байгаа эсэхийг нь судлах шаардлагатай юм.

Улс төрийн хүрээнд ардчиллыг явцуу байдлаар тодорхойлбол, энэ нь бүх нийтийн чөлөөт сонгуулиар сонгогчдын олонхын санал авч дэмжлэг хүлээсэн улс төрийн хүчний хуулиар тогтоосон хугацаанд засаглах эрх юм. Ардчиллын ийм загвар нь дотроо зарчмын гэмээр зөрчил агуулдаг. Нэг талаас сонгогчдын сонгох эрх ба сонгогдсон засгийн үйл ажиллагааны үр дүн хоёр тэр бүр

нийцдэггүй. Сонгогчид аж амьдралаа сайжруулах гэх мэт өөрийн ашиг сонирхолтой холбоотой хүлээлттэй байдаг бол сонгогдсон хүмүүс тэрхүү хүлээлтийг хангах чадваргүй юм уу боломжгүй байдаг. Үүнтэй холбоотойгоор Платон ардчилалд эргэлзэж байжээ. Түүнийг Дураны дамжуулснаар эшилбэл: “...гугал хийх гэх мэт энгийн зүйлд бид зөвхөн тусгайлан бэлтгэгдсэн хүн л бидний хүслийг биелүүлж чадна гэж боддог бол улс төрд болохоор хүмүүсийн саналыг авах арга барилыг мэддэг хүн бүр хот, сууриныг хэрхэн удирдахаа мэддэг гэж үздэг. Бид өвдөж байхдаа мэргэшсэн эмчийг дууддаг, түүний зэрэг нь тодорхой бэлтгэл, техникийн ур чадварын баталгаа болдог - бид царайлаг эмч эсвэл хамгийн уран яруу ярьдаг эмчийг урьдаггүй; За тэгвэл улс бүхэлдээ өвдсөн үед бид хамгийн мэргэн, шилдэг хүмүүсийн үйлчилгээ, удирдамжийг хүсэх ёстой биш үү?” (Will Durant, 27) Тэр бээр “Нийтийн албанд албан тушаалыг хаших чадваргүй, заль мэхтэй хүмүүс орохыг хориглох, нийтийн сайн сайхны төлөө удирдах хамгийн чадвартай хүмүүсийг сонгох, бэлтгэх аргыг олох нь улс төрийн философийн асуудал юм” гэж үзэж байжээ. Харамсалтай нь ийм аргыг одоог хүртэл олж чадаагүй байгаа юм. Бүх нийтийн оролцоотой сонгууль үүсэхтэй мөр зэрэгцэн улс төрийн бохир технологи ихээхэн хөгжсөн нь ухаалаг сонголт хийх боломжийг бүр ч багасгасан юм. Мэдээллийн хомсдол ч, мэдээллийн илүүдэл ч сонгогчийн сонголтыг гажуудуулах нөлөөтэй байгаа юм. Их өгөгдлийг ашиглан сонгогчдыг судлах, дундаж сонгогчийн дүр зургийг тодорхойлох, улмаар түүнд нийцсэн амлалт өгөх, нэр дэвшигч түүний сэтгэлд нийцэх имижийг харуулах зэрэг сонгогчийг “мэхлэх” боломж улам бүр ихсэж байна.

Нөгөө талаас сонгуулийн компанит ажил хэтэрхий үнэтэй болсон нь санхүүгийн зохих эх үүсвэртэй юм уу эсвэл санхүүжилт олж чадах хүмүүс л нэр дэвших боломжтой болж байна. Тийм хүн болгон төрийг удирдах юм уу, бодлогыг зөв тодорхойлох чадвартай байдаг гэдэг нь эргэлзээтэй бөгөөд, нэлээд тохиолдолд тийм чадваргүй байдаг. Чадвартай хүмүүс улс төрөөс зай барих нь бас элбэг. Эдгээр нь дэлхий нийтийг хамарсан үзэгдэл. Тийм ч учраас дээр бүтээлтээс нь эшлэл авсан сэтгэгчид өнөө үеийн улс төрийн сонгууль нь ямар нэг өндөр дээд үзэл санаанд тулгуурлаагүй эрх мэдлийн төлөөх өрсөлдөөн болж байна хэмээн үзэж байна. Улс төрийн олон хүчний өрсөлдөөн бол ардчиллын гол зарчмуудын нэг. Түүнийг хэрхэн утга учиртай болгох вэ? Намын тухай, сонгуулийн тухай гэх мэт хууль тогтоомж гаргаж, тэдгээрийг мөрдөхийг шаардах нь хангалттай юу?

Өнөөгийн ардчиллын бодит байдлыг харвал шууд л үгүй гэж хариулах нь бараг л үнэнд нийцэх юм. Эрх мэдлийн төлөөх өрсөлдөөн бараг л хүний төрөлхтөнтэй өөртэй нь чацуу байх. Би өмнөх өгүүлэлдээ улс төрийн өрсөлдөөн, түүний хэтрэлтээс үүдэн талцал, популизм зэрэг зохисгүй үзэгдэл гардаг тухай нэгэнт бичсэн тул энэ удаа өрсөлдөөний тухай сэдвийг илүү дэлгэрүүлэхгүй.

Ардчиллын бас нэг зөрчилтэй зүйл нь тэгш эрхийн зарчим юм. Улс төрд “нэг хүн-нэг санал” зарчмаар, эдийн засагт хувьцааны хэмжээгээр гэх мэтээр эл зарчмыг амьдралд хэрэгжүүлэх аргууд буй болсон юм. Гэвч сэтгэл зүйн шинжтэй өөр нэг хандлага гардаг нь монгол хэлээр хамгийн энгийн байдлаар илэрхийлбэл атаархал юм. Алексис де Токвиль “Хүний сэтгэлд тэгш байдлын тухай гажуудмал таашаал нуугдаж байдаг нь сул хүмүүст хүчтэй хүмүүсийн өөрсдийнхөө түвшинд хүртэл доош

унагах эрмэлзэл төрүүлдэг ба энэ нь улмаар хүмүүсийн эрх чөлөөтэй бөгөөд тэгш бус байдалтай байснаас боолчлолд тэгш байдалтай байсан нь дээр гэж үзэхэд хүргэдэг гэжээ.” Энэ бол ардчилалд аюул учруулах магадлалтай үзэгдэл юм. Авьяас, чадвартай хүмүүс, үндэсний том компаниуд улсын хөгжлийг манлайлдаг нь маргаангүй зүйл юм. Гэвч шударга ёс тогтоох нэрийдлээр бүгдийг тэгшитгэх гэх нь Токвилийн илэрхийллийг ашиглавал “боолчлолд тэгш байдалтай байх” зам руу орж байна гэсэн үг юм. Атаархал биш боловч энэ дашрамд тэмдэглэмээр өөр нэг зүйл бол аливаа Засгийн газар дэмжигчдээсээ үл дэмжигч олон байх нөхцөлд ажилладаг гэвэл бараг хилсдэхгүй юм. Тухайн улс төрийн хүчнийг дэмжээгүй хүмүүс болон сонгуульд оролцож саналаа өгөөгүй хүмүүс нийлээд олонх болох тохиолдол ч элбэг гардаг. Ийм нөхцөлд засгийн газраас хэрэгжүүлж байгаа олон нийтэд эмзэг боловч, ирээдүйг харсан шийдвэрүүд эсэргүүцэлтэй тулгарах нь элбэг. Атаархал, өнөө маргаашийн сэтгэлгээнээс үүссэн олон нийтийн юм уу түүний аль нэг хэсгийн хүсэл сонирхолд нийцүүлэх гэж оролдвол ардчилсан төр засгийн зорилгод харш юм. Учир нь ардчилал бол бүх нийтийн сайн сайхны төлөө асуудал болохоос бус, нэг хэсгийн төлөө биш юм. Товчхондоо “expropriation of the expropriators” гэдэг уриа бол зарим тохиолдолд маш аюултай байдаг.

Ардчиллын мөн чанарт оршдог эдгээр зөрчилтэй талуудыг улс төрийн намын үйл ажиллагаа, мэргэжлийн засгийн газар нэлээд зөөлрүүлдэг. Онолын хувьд нам нь төрийн бодлогын хувилбарыг боловсруулж, сонгогчдод түүнийгээ санал болгох учиртай. Түүнчлэн түүнийг хэрэгжүүлэх хүмүүсийг бэлтгэн сонгуульд нэрийг нь дэвшүүлэх, төрийн албанд байршуулах нь улс төрийн намын нэг чухал үүрэг юм. Нам нь олон

түмэнтэй тогтоосон холбоогоороо сонгогчдын улс төрийн боловсролыг дээшлүүлж байх учиртай гэж үзэж ирсэн билээ.

Хүн төрөлхтний улс төрийн амьдралд тодорхой үзэл суртал бүхий улс төрийн намууд үүссэн нь өрсөлдөөнийг учир утгатай болгож байсан үе бий. Улс төрийн нам үүсэж байх тэр үед тэр нь нийгмийн аль нэг анги юм уу хэсгийн хамгийн зохион байгуулалттай хэсэг нь байв. Тиймээс ч европ дахины хэлний “хэсэг” гэсэн утгатай “партия”, “party” гэсэн үндэстэн бүрийн хэлээр бага зэрэг ялгаатай боловч төстэй нэрийг түүнд өгсөн хэрэг байх. Монгол хэлний “нам” гэдэг нэрийг “нам нийлж, сэм хуйвалдах” гэсэн санаанаас үүсэлтэй гэх нь тохиолддог боловч энэ нь тийм ч үндэслэлтэй бус, уран зохиолын дүрслэлтэй холбоотой байх. Тухайлбал, Ч. Лодойдамбын Тунгалаг тамир романд “Манай ноён Өөлдийн Амарсанаа, шадар бэйс Чингүнжавтай нам нийлж, сэм сүлбэлдэж, Монголоо Манжаас салгаж авъя гээд тангараглан ярилцаад адаг сүүлд нь болохоор Манжийн хаанд ховлочихсон юм гэнэ лээ” гэсэн өгүүлбэр байдаг. Энд байгаа “нам нийлж” гэснийг нам байгуулсан гэдэг утгаар бус санаа нийлж гэсэн утгаар ойлгомоор санагдаж байгаа юм. Монгол хэлний “нам” гэдэг үг дөрвөн янзын утгатай. Тэдгээрийн дотор “хэсэг”, “аймаг” гэсэн агуулга бас бий. Улс төрийн нам хожуу үүссэн болохоор нам гэдэг үгийн анхны утгын нэг нь энэхүү “хэсэг” гэсэн утга байсан байх. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд жишээ болгон “мийн нам”, “сонгинын нам” гэж амьтан ургамлын аймаглалыг дурдсан байна. Намыг анх үүсгэн байгуулж байсан хүмүүс гаднын улс төрийн амьдрал, түүний дотор нам гэдгийн агуулгыг мэддэг байсан гэж үзэж болох юм.

Улс төрийн намууд XVIII зууны эцсээр үүсэж XIX зуунд ихэд хөгжсөн

юм. Морис Дюверже улс төрийн намын-хөгжлийг парламентад ёсны хөгжилтэй уялдаатай хэмээн үзсэн байдаг. Улс төрийн намын түүхэн хөгжлийг М. Вебер үечилсэн бөгөөд улс төр судлалын ном зохиолд түүнийг ихэвчлэн баримталдаг. Эхний үед улс төрийн нам язгууртнуудын бүлэглэлийн хэлбэртэй байжээ. Хоёр дахь үеийн намууд улс төрийн клуб хэлбэртэй байсан аж. Харин гуравдахь үед нам нь өнөөгийн намын дүр төрхийг олсон аж. Анхны намууд Англид үүссэн бол Францын хувьсгал нь үзэл сурталд суурилсан олон намуудыг буй болгосон юм. XIX зууны сүүлч, XX зууны эхний хагаст бүх нийтийн сонгуулийн эрх түгээмэл болсон нь улс төрийн намуудын хөгжилд шинэ үеийг авчирсан байна. Улс төрийн намуудын өөрчлөлтийн үйл явцыг түүхчлэн дурдахгүйгээр үндсэн үр дүнг нь дурдах юм бол XX зууны намуудыг олон түмний, кадрын, “бүхнийг хамагч” (all-catch) хэмээн ангилж ирсэн нь тэдний хувьслын үр дүн байсан гэж болно. Олон түмний нам нь гол төлөв зүүн чиглэлийн үзэл сурталтай, олон тооны гишүүдтэй, зохион байгуулалтын тодорхой бүтэцтэй байдаг байсан ба гол төлөв нийгмийн доод хэсгийн эрх ашгийг илэрхийлж байжээ. Тэгвэл кадрын нам нь консерватив юм уу либерал үзэл сурталтай, олон тооны гишүүнгүй-намууд байж ирсэн.

Орчин үед хэдийгээр олон түмний намууд оршин тогтносоор байгаа боловч-улс төрийн намууд илүү их кадрын шинжтэй болж хувьсаж байна. Орчин-үеийн кадрын намын гол шинж бол:

- Цөөн гишүүдтэй боловч харьцангуй-олон сонгогчийн саналыг авдаг,
- Гишүүд нь гол төлөв намыг санхүүжүүлэх, байнгын ажиллагаатай байхад нь оролцдог,
- Намын амьдралд мэргэжлийн улс төрчид голлох үүрэгтэй байдаг,
- Зохион байгуулалтын босоо тогтолцоотой

Сонгогчдын тодорхой бүлэгт хандах нь багассан боловч “бүхнийг хамагч” бус Эндээс харвал кадрын намууд зарим талаар олон түмний намын шинжтэй болж байгаа гэж болох юм. Гэтэл нөгөө талаас олон түмний намууд кадрын намын зарим шинжүүдийг олон хувьсаж байгаа юм. Тэдгээрийн хувьд өмнөх үе шигээ олон тооны гишүүдтэй байх бололцоо ихээхэн хумигдаж, намын төв байгууллага, мэргэжлийн улс төрчдийн нөлөө ихсэж байна. Энэ бүхэн нь олон түмний болон кадрын намууд өөр хоорондоо улам бүр төстэй болж байгааг харуулна. Намуудын нийгмийн бүтэц өөрчлөгдсөн нь намууд сонгуульд ялалт байгуулахын тулд нийгмийн зөвхөн нэг юм уу цөөн бүлэгт хандахаа больж сонгогчдын хүрээгээ тэлэх шаардлага гарсан. Үүнтэй холбоотойгоор “бүхнийг хамагч” намууд гарч ирлээ гэж үзэх болжээ. Уг нэр томьёог О. Киркхаймер эргэлтэд оруулсан гэдэг. Ийм намууд нь нийгмийн янз бүрийн хэсэгт хандсан сонгуулийн хөтөлбөр гаргаж, сонгогчдод санал болгодог байна. Үүнийг О. Киркхаймер “бодлого гаргахын тулд сонгуульд ялах бус, сонгуульд ялахын тулд бодлого гаргадаг” хэмээн тодорхойлсон байдаг. Бүхнийг хамагч” намын үндсэн шинж нь:

Үзэл суртлын хувьд тодорхойгүй, хөтөлбөртөө үзэл суртлын холбогдолтой зүйлийг оруулдаггүй,
Энгийн гишүүдийн үүрэг, нөлөө бага намын удирдлага хүчтэй,
Намын удирдлагад мэргэжлийн улс төрчид зонхилдог,
Нийгмийн янз бүрийн бүлэг, хэсгийн дэмжлэгийг авахыг эрмэлздэг явдал юм. Нам судлалын ном зохиолд “картель нам” гэсэн нэр томьёо элбэг хэрэглэгдэх болсон нь улс төрийн намын хувьслын бас нэг шинжийг илүү тодотгож байгаа хэрэг юм. Үүнийг намын гишүүдийн тоо цөөрсөн, хүн амын дийлэнх хэсэг нь “намын эсрэг” байр суурьтай болсон,

иргэд хэдийгээр төрийн эрх мэдлийн төлөө тэмцэхгүй ч гэсэн нам бус хөдөлгөөн маягаар улс төрд нөлөөлөх болсон, түүгээр ч барахгүй шууд эсэргүүцэл илэрхийлэх аргыг хэрэглэх болсон зэрэгтэй холбон үзэж байна. Эдгээр намуудын ерөнхий шинж нь нам хоорондын харилцаа нягтарсан (зарим судлаачдын бичиж байгаар намуудын хуйвалдаан), нам төрийн зааг ялгаа багассан зэрэг аж. “Картель нам”- ын зарим онцлог шинж гэвэл:

- Намууд хоорондын өрсөлдөөн суларч, уламжлалт бус тоглогчдын нөлөөг хязгаарлахыг оролдох болсон,
- Намууд төрийн санхүүжилт авах, төрийн мэдлийн мэдээллийн хэрэгслийг ашиглах зэргээр төртэй “ууссан” байдалтай болсон,
- Улс төрийн үйл ажиллагаа мэргэжлийн шинжтэй болсон
- Намын дотор төрийн өндөр алба хашиж байгаа хүмүүсийн нөлөө давамгайлдаг,
- Олон түмнээс “тасарч “ байгаа зэргийг юуны өмнө дурдаж болох юм.

Улс төрийн намын хувьслын үйл явцыг ийнхүү товчхон мөшгөж үзэж юм бол бидний дээр ардчиллын сул тал гэж нэрлэсэн зүйлүүдийг аль болохоор зөөлрүүлэх тийшээ өөрчлөлт явж байна. Улс төрийн үйл ажиллагаа мэргэжлийн болж байгаа нь бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажил мэргэжлийн болж байна гэсэн үг юм. Тиймээс сонгогч нэр дэвшигчдийн алийн нь төлөө саналаа өгсөн ч тодорхой бэлтгэлтэй хүнийг сонгоно гэсэн үг юм. Намууд үндсэн асуудлаар зөвшилцөж, сонгуульд өрсөлдөхдөө тухайн үед олны анхаарал татаж байгаа тодорхой асуудлаар зөрөөтэй байр суурь илэрхийлдэг болсон нь шударга ёс, тэгш эрх мэтээр дулдуйдсан хэт экстремист хөдөлгөөн төрийн эрхэнд гарахыг хязгаарлаж байна.

1. Гэвч улс төрийн намын хувьсал, 2. одоогийн байгаа байдал улс орон бүрд 3. ийм байгаа гэсэн үг биш. Улс төрийн

намын нөлөө багасаж байна гэж байгаа боловч өнөөдөр дэлхийн улс орнуудын улс төрийн амьдралд намууд гол тоглогч болсон хэвээр байгаа юм. Улс төрийн намын хувьслын тухай дээр өгүүлсэн зүйлс бол өрнөдийн орнуудын улс төрийн намын хувьсалтай илүү холбоотой юм.

Манай улс ардчиллыг улс төрийн амьдралд нэвтрүүлэхдээ өрнөдийн загварыг ухамсартайгаар болон ухамсарлахгүйгээр чиг баримжаа болгож байгаа болохоор тэдгээр орны улс төрийн намын хувьслын тухай зориуд хөндөж байгаа юм.

Түүнээс гадна дэлхийн геополитикт гарч байгаа өөрчлөлтүүд, зөрчилдөөн, олон туйлт дэг журмыг буй болгох оролдлого зэрэг нь дотоод дахь улс төрийн хагарал гаргахгүй, хурц ширүүн өрсөлдөөнийг аль болохоор аядуу байлгах, учир утгагүй талцал, хагарлаас татгалзах шаардлагыг буй болгож байна. Энэ бол магадгүй орчин үеийн Монголын намуудын түүхэн үүрэг байх. Тиймээс өрсөлдөөний ардчиллаас зөвшилцлийн ардчилалд шилжих нь Монгол улсын хувьд цаг үеийн шаардлага болж байна. Ардчиллын нэг чухал хэрэгсэл бол өрсөлдөөн зайлшгүй мөн. Гэвч энэ нь улс төрийн талцал, хагарал, дайсангал байж таарахгүй юм. Ардчиллын онолын эх суурийг тавигчид ардчиллыг зөвхөн өрсөлдөөн гэж үзэж байсангүй. Жишээ нь Т. Гоббс байгалийнхаа байдлаар байгаа хүмүүсийн 19 хуулийг тодорхойлсон байдаг. Түүний эхний хууль нь энхийг эрхэмлэх, энх тайвныг тогтоох нь байгалийн байдлаас урган гарч буй нэгдэх хууль гэж үзсэн байдаг. Түүнчлэн 5-р хууль нь зохицохыг эрмэлзэх, 6-р нь уучлах гэх мэт. Тэгвэл Ш. Л. Монтескье мөн ийм дөрвөн хуулийг томьёолсон байдаг. Үүнд:

1. Энхийг эрмэлзэх,
2. Хүнс тэжээл хайх,
3. Хоорондоо ойртож нөхөрлөх, бие биеэс тусламж гуйх,

4. Нийгэмд амьдрахыг эрмэлзэх.

А. Д. Токвиллийн бүтээлд хүмүүс тэгш эрхтэй байх, хамтран аж төрөх эрмэлзэлтэй байх нь ардчиллыг хөгжүүлдэг гол нөхцөл болохыг АНУ-ын Шинэ Англид суурьшсан пуританчуудын жишээгээр харуулсан байдаг билээ.

Энэ бүхнээс үзвэл сонгодгууд хүн гэдэг амьтны төрөлх мөн чанарт энхийг эрхэмлэх, хоорондоо зохицож хамтран аж төрөх тэмүүлэл шингэсэн байдаг хэмээн үзэж байсан байна.

Өрсөлдөөн ардчиллыг хэрэгжүүлэх нэг арга мөн. Харин ардчиллын эх суурь, мөн чанар нь зөвшилцөл юм. Гудамжинд хаалт боолт босгон буудалцахын оронд асуудлыг хэм хэмжээ тогтоон тайвнаар шийдвэрлэх гэсэн үзэл санаа, үнэлэмж юм.

Манай орны намууд хэдийгээр малчид, тариаланчид, жижиг дунд үйлдвэрлэгчид гэх мэт нийгмийн тодорхой бүлгүүд буй болсон боловч гол төлөв нийт ард түмний нэрийг барьсан уриа лоозонтой байна. Бодлогыг үзэл суртлын байр сууринаас харвал ялгаа багатай байгаа бөгөөд зарим тохиолдолд өөрийн тунхагладаг үзэл суртлаас эсрэг чиглэлийн бодлого, үйл ажиллагааг явуулах нь ч ажиглагдаж байгаа юм. Сүүлийн гучаад жилийн байдлыг харвал нийгмийн санаа бодлыг дагалдан залуу, туршлагагүй хүмүүсийг хэт олноор нь төрийн албанд дэвшүүлж байгаа нь улс төрийн үйл ажиллагаа мэргэжлийн гэхээсээ илүү мэргэжлийн бус чиглэл рүү явах хандлагыг буй болгож байна.

Хэдийгээр улс төрийн амьдралын олон гэм сэвийг дурдаж болох боловч үүгээр хязгаарлан зөвшилцлийн

бодлого, хөтөлбөртөө тусгах шаардлагатай болдог. Нийгмийн олон хэсэг бүлгээс авсан саналын тоо нь тус бүрдээ цөөн боловч нийлбэр дүнгээрээ нэлээд хувь дарж болох жишээтэй юм. Энд өгүүлснийг доорх зурагт дүрслэхийг


ардчилал буй болох боломжийн тухай асуудлыг сөхье.

Хүн ам цөөтэй, эдийн засгийн болон, батлан хамгаалах чадавх султай манай орны хувьд дотооддоо хагарал тэмцэлгүй байх, хөгжлийн бодлогыг тогтвортой мөрдөх хэрэгцээ тулгарч байна. Хэт улс төржилт, бодлогын тогтворгүй байдал зэрэг нь улс орны хөгжлийн боломжийг үрэн таран хийх аюултайгаас гадна улс орны гадаад дүр төрхийг ч бүдгэрүүлж байгаа юм. Манай оронд улс төрийн байршлын хувьд хэт барууны юм уу зүүний нам байхгүй байгаа нь зөвшилцлийн ардчилал буй болоход бас нэг таатай нөхцөл юм.

Хэрвээ улс төрийн хүчнүүдийг орчин үед давамгайлж буй үзэл суртлын юм уу, бодлогын чиглэлээр нь авч үзвэл уламжлалт баруун -зүүн гэдгээс гадна шашны, үндэсний, экологийн гэх мэтээр ангилж болох юм. Эдгээрийн өөр өөрийн нь тэнхлэг дээр байршуулбал, тухайн үзэл суртлыг баримтлах байдлаараа ихээс бага гэсэн хоёр туйлтай байна хэмээн төсөөлж болох юм. Тэгж үзвэл аль нэг нам шашинд болон үндэсний гэсэн хоёр тэнхлэг дээр байршиж болох жишээтэй. Үндэсний үзэл баримталдаг намууд гол төлөв баруун чиглэлтэй байдаг гэх мэт. Хэрвээ уг нам экологийн асуудалд төдийлөн анхаардаггүй экологийн тэнхлэгийн хасах талын төгсгөл хавьцаа байршиж болох жишээтэй юм. Өөрөөр хэлбэл улс төрийн ямар ч нам цэвэр нэг л үзэл суртлыг баримталдаггүй гэсэн үг. Тэр тусмаа орчин үеийн “бүхнийг хамагч” нам, тэр ч байтугай картель нам сонгогчдын янз бүрийн хэсгээс цөөн тооны атугай ч санал авахын тулд амьдралын олон талын асуудлыг ямар хэмжээгээр сөхөх, оролдсон болно. Аль нэг улс оронд байгаа улс төрийн намуудыг бүгдээрээ төв тойрсон байршилтай гэж үзвэл зөвшилцөлд орох асуудлын хүрээ тэнхлэгүүдийн уулзварт байгаа тойргоор дүрслэгдэнэ. Улс төрийн намууд олон

янзын өнгө төрхтэй байж болох учраас тэнхлэгүүдийн хооронд байрших нам ч байж болох талтай. Ийм тохиолдолд тэнхлэгүүдийг гурван хэмжээст орон

зайд байршуулан сэтгэж болно. Тэгвэл голын тойрог маань бөмбөрцөг хэлбэртэй болно.



Зураг 1. Улс төрийн хүчний байршил, зөвшилцлийн бөмбөрцөг

Голын тойрог буюу бөмбөрцөг нь улс төрийн хүчнүүдийн зөвшилцлийн үндсэн суурь болно. Түүнд үндэсний эрх ашгийн гол үзэл баримтлал, түүнээс урган гарах гол гол асуудлууд багтана. Тэнд байгаа асуудлыг улс төрийн ямар ч хүчин баримталж, хэрэгжүүлэхийг чармайх ёстой. Тийм болохоор голын тойрогт байгаа асуудлуудыг улс төр, үзэл суртлаас хамааралгүй гэж үзэж болох юм. Хэрвээ энд байгаа асуудлуудаар улс төрийн хүчнүүдийн хооронд зөрчил үүсэж хурцадвал тектоникийн хөдөлгөөн гарч, газар хөдлөхийн адил улс төрийн ноцтой хямрал, тэр ч байтугай тухайн нөхцөл байдлаас хамааран төрийн эргэлт, иргэний дайн хүртэлх аюулд хүргэж болох талтай.

Харин гадна талын бөмбөрцөгт ойрын болон дунд хугацааны зорилтууд, нийгмийн анхаарал төвлөрч, тухайн үед яриа хэлэлцүүлэг өрнөж байгаа асуудлууд багтана. Онолын хувьд сонгуулийн өрсөлдөөний сэдвүүд ч эндээс гарах болно. Нэгэнт улс төрийн хүчнүүд төвийн байршилтай гэж үзэж

байгаа болохоор гадна талын тойрог буюу бөмбөрцөгөөс гадагш хальсан сэдвүүд хөндөгдөхгүй юм уу, эсвэл бага хөндөгдөнө. Энэ нь ихэвчлэн намын системд төдийлөн байр суурьгүй, сонгогчдын анхаарлыг татах гэсэн популист намуудын хийх ажил гэж болох юм.

Тогтвортой ардчилал бүхий улс орнуудын намын систем ажиглахад энд өгүүлсэнтэй төстэй байдаг. Намын системийн ийм загвар, үйл ажиллагааны зарчим нь ардчиллын зарчмуудад байдаг зөрчлүүдийг туйлшруулахгүйгээр тодорхой хязгаарт барих боломж олгодог байна. Хэрвээ ямар нэг шалтгаанаар туйлшрал гарвал дээр дурдсан сэтгэгчдийн үзэж байгаагчлан “ардчилал ардчилал хэтэрснээс” нуран унах болно. Улс төрийн байршлын хувьд төвд орших намууд зөвшилцөж чадахгүйгээс үүдэн нийгэмд хямрал үүсэж, иргэдийн аж амьдрал доройтвол сонгогчид ямар нэг туйлширсан, экстремист маягийн хүчинд санал өгч, ардчилал ялагдал хүлээж байсан тохиолдол хүн

төрөлхтний түүхэнд гарч байсан билээ. Платон ардчилал олигарх болж хувирах болно хэмээн үзэж байсан. Их сэтгэгчийн энэ үзэл зарим талаар үнэний

- Бодлогын үндсэн гол асуудлаар улс-төрийн хүчнүүд зөвшилцөлд хүрч, түүнийг иргэд ойлгодог болсон-тохиолдолд Платоны ац асуудал ямар нэг хэмжээгээр шийдвэрлэгдэнэ. Учир-нь зөвшилцөл хийсэн бодлого нь намуудын тинк танк байгууллагууд, засгийн газар, их сургууль, эрдэм-шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүн байх болно. Урьдчилсан ийм олон талт-судалгаагүйгээр хэдхэн намын ажилтан тэр байтугай намын их хурал ч бодлогын-ийм том асуудлыг тодорхойлж чадахгүй. Өрсөлдөөний ардчиллаас зөвшилцлийн ардчилалд шилжих нь хугацаа эзэлсэн төвөгтэй үйл явц байх болно. Зөвшилцлийн үйл явц цаг хугацаа шаардахаас гадна түүнийг хэрэгжүүлэх явцад гарах саад бэрхшээл, түүнийг даван туулахын төлөө чармайлт хэрэгтэй. Энэ нь намын систем, намуудын төлөвшил ямар байгаагаас ихээхэн хамааралтай. Улс төрийн хошуучлагчдаас тэвчээр, ухаан шаардсан үйл явц юм. Албан тушаалын амбиц болон бусад жижиг сажиг асуудлаас үүдэн зөвшилцлөөс ухрах гэх мэт асуудал олонтоо гарах болно. Зөвшилцөл нь төвөгтэй үйл явц мөнөөс гадна маш эмзэг. Ангал хавцлын дээгүүр маш нарийхан гүүр юм уу олс дээсэн дээгүүр явж байгаа мэт байнга үйл хөдлөлөө тохируулж байхыг шаарддаг. Өчүүхэн жижиг асуудлаас үүдэн сөргөлдөөн үүсэх, эвсэл задрах гэх мэт аюул гардаг. Үүнээс сэргийлэх нь улс төрийн ухаан юм. Улс төрийн намын төлөвшлийг юугаар тодорхойлох вэ? Энд юуны өмнө тухайн нам онолын хувьд нийгэмд гүйцэтгэдэг үүргүүдээ хэрхэн хэрэгжүүлж байна вэ гэдэг нь үзүүлэлт болно.

хувьтай боловч энэ нь зайлшгүй зүйл биш юм.

Бодлого боловсруулах,
Иргэдийг төлөөлөх,

Иргэдийн нийгэмшилд дэмжлэг үзүүлж, үнэлэмжийг төлөвшүүлэх,
Сонгуульд ялсан болон эвсэлд орсон тохиолдолд засгийн газрыг байгуулах, төрийн байгууллагуудыг уялдуулах,
Засгийн газарт хяналт тавих, Үндэстнийг төлөвшүүлэх, Олон нийтийн санаа бодлыг төлөвшүүлэх,
Нийгмийг зохион байгуулах, модернизац хийх,

Иргэдэд улс төрийн боловсрол олгох. Улс төрийн нам нийгэмд ийм өргөн хүрээтэй нөлөө үзүүлдэг байх ёстой. Энэ нь намын удирдлагын боловсрол, төрийн ухаан, алсын хараа, улс орны эрх ашгийг урьдач болгох гэх мэт олон шинж чанарыг шаардана. Улс төрийн нам эрх баригч байсан ч, сөрөг хүчин байсан ч бурууг буруу гэдэг, зөвийг зөв гэдэг байх ёстой. Түүнчлэн ялж, ялагдаж сурах, бүхий л үйл ажиллагаандаа үндсэн хуулийг ягштал мөрдөх нь намын төлөвшлийн чухал шинж байх болно. Орчин үед улс орны ойрын болон хэтийн зорилгыг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулах нь зөрчилтэй байдаг. Тиймээс олон нийт зөв зүйлийг ч эсэргүүцэх тохиолдол гараг. Иргэд ихэвчлэн өнөөдрөөр сэтгэдэг учраас хэтийн зорилгыг төдийлөн ойлгохгүй байх нь цөөн биш удаа гардаг. Улс төрийн нам сөрөг хүчин байгаа гэдэг шалтгаанаар тохиолдол бүрд “гудамжтай” нийлээд байж болохгүй юм. Үндэсний нэгдэл, нягтралыг хамгаалах, улсын аюулгүй байдлыг бэхжүүлэхэд өөрийгөө хүндэтгэдэг бүхий л улс төрийн нам бүр хувь нэмэр оруулдаг байх үүрэгтэй. Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, засгийн газрыг огцруулах зэрэг чухал шийдвэр нь хувь

гишүүний ганцаарчилсан тоглолт бус-намын хамтын шийдвэр байх нь чухал юм.

Зөвшилцлийн тогтвортой горимыг хадгалахад төр талдаа ч тодорхой нөхцөлүүдийг хангах нь чухал бололтой. Үүнд юуны өмнө дараах зүйлсийг онцолж болох юм.

- Төрийн албыг аль болохоор улс төрөөс салгах. Үүнд төрийн алба хаагчдыг шилэн сонгох, томилоход клиентелийн зарчмыг хэрэглэхгүй байх. Улс төрчид улс төрийн нөлөөгөө ашиглан өөрийн хүмүүсийг төрийн албанд байршуулах нь төрийн албыг тогтворгүй болгох, төрийн алба мэргэжлийн бус, туршлагагүй болох, бодлогын залгамж холбоо сулрах, алба хаагчид дээд талын “ивээлд” найдан авлига авах мэтээр хууль зөрчих зэрэг олон сөрөг үзэгдэл чухамхүү клиентелизмтэй холбоотой байдаг. Захиргааны алба тогтвортой, мэргэжлийн байх нь эрх баригч хүчин солигдлоо ч гэсэн бодлого залгамж холбоотой, шинжлэх ухааны үндэстэй байх үндэс болохын зэрэгцээ, үүнийхээ ачаар ч зөвшилцлийн ардчилал төлөвших суурь болно. Орчин үед төрийн бодлого нь улс төрийн үзэл суртал гэхээсээ илүү шинжлэх ухаанд суурилах болжээ.
- Хуулийг чанд мөрдөх. Тоглоомын дүрмээ мөрдөхгүй бол ямар ч зөвшилцөл байх боломжгүй. Үүний тулд юуны өмнө, цагдаа, шүүхийн байгууллагыг шинэчлэх, чадварлаг болгох нь авлига мэтийн ёс бус үзэгдэлтэй тэмцэх, хуулийг бүх нийтээр мөрддөг болохын хамгийн эхний бөгөөд хамгийн чухал зорилт юм. Зүйрлэвээс малын дайсан чоныг агнахын тулд мэргэн тусдаг буутай байх хэрэгтэй нь мэдээж. Буу баардаг, байндаа тусдаггүй бол чоныг агнах тухай санахын ч хэрэггүй юм. Тийм учраас юун ы өмнө цагдаа, шүүх, прокурорын байгууллагыг системээр нь сайжруулж, үр нөлөөтэй болгох нь чухал юм.

Улс төрийн зөвшилцөлд оролцож байгаа талуудын хувьд бодлогын асуудлаар зөрчилдөх явдал гарахаас гадна эдийн засгийн сонирхлоос үүдсэн зөрчил гардаг нь нууц биш. Эдийн засгийн шинжтэй зөрчил нь тендер, төсөл гэх мэттэй холбоотой бөгөөд ихэвчлэн өрсөлдөөн далд, заримдаа “хөшигний цаана” явагддаг учраас хамгийн хортой юм. Олон улсын туршлагыг харваас ийм байдлаас сэргийлэх гол хэрэгсэл бол төрийн гэж нэрлэгддэг өмч, санхүүгийн салбарт хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлдэг хүчтэй хяналтын байгууллагатай байх нь асуудлыг шийдвэрлэх нэг хувилбар байж болох юм. Зарим улсад хяналтыг төрийн эрх мэдлийн дөрөв дэх салбар болгон үндсэн хуулийн статустай тусгай системийг буй болгодог туршлага байна. Хяналт сайн байх нь төрийн мөнгө, санхүүгийн үйл ажиллагаа тунгалаг байх, элдэв явуулга, хардлага, хов жив үүсэхээс сэргийлнэ.

Зөвшилцлийн ардчилалд иргэдийн улс төрийн соёл, иргэний нийгмийн эрүүл саруул үйл ажиллагаа чухал юм. Нийгэм зөвшилцөл болгоныг хуйвалдаан, “бялуу хуваалт” хэмээн үзэх юм бол улс төрийн зөвшилцөл хэзээ ч байхгүй. Тиймээс иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх нь чухал болж байгаа юм. Ялангуяа олон нийтийн мэдээллийн хэрэгсэл зөвшилцөлд зөв байр сууринаас хандах нь чухал болно. Зөвшилцлийн ардчилалд шилжихэд сонгуулийн системийг оновчтой болгох асуудал чухал байр эзэлнэ. Энэ талаар би өмнөх өгүүлэлдээ (Ардчилал ба хөгжлийн асуудал) нэлээд дэлгэрэнгүй авч үзсэн билээ.

Ашигласан материал

А. Цанжид ФЭС 2024

Crozier, Michel J., Huntington, Samuel P., and Joji Watanuki. The Crisis of Democracy. Report on the governability of Democracies to the Trilateral Commission. New York University Press. 1975

Durant, Will. The Story of Philosophy. Pocket books, 2006

Grayling, A. C. Democracy and Its crisis. London, 2018

Tocqueville, Alexis de. Democracy in America. Wordsworth classics of world literature 1998

Кола, Доминик. Политическая социология. ВЕСЬ МИР. Издательский Дом “ИНФРА-М” М., 2001

Розмозер, Гюнтер. Кризис либерализма. ИФРАН М., 1996

Шестопап Е.Б. Политической психология. ИНФРА-М, М., 2002